

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН МӨНХ ҮЙЛСТЭН ӨЭМТ-ИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2026/193/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 327734 Цахим хаяг: andinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Ашид баланс аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com
-----------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус төвийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар 13 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх үйлстэн ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 захирамжаар 87.0 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 97.2 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ХӨРӨНГИЙН ДҮН		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,786,644.11	2,578,836.09
1.1.2	Авлага	57,459,933.18	24,839,367.97
1.1.6	Бараа материал	69,914,884.77	62,921,686.82
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	129,161,462.06	99,904,357.41
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	86,604,531.28	62,921,686.82
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	86,604,531.28	62,921,686.82
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	215,765,993.34	162,826,044.23
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Дансны өглөг	-	17,045,819.85
2.2	Өр төлбөрийн дүн	-	17,045,819.85
2.3	Эздийн өмч	55,379,883.21	55,379,883.21
2.3.1	Өмч-төрийн	55,379,883.21	55,379,883.21
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,914,334.64	3,914,334.64
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	156,471,775.49	156,471,775.49
2.3.10	Тайлант үеийн үр дүн		(69,985,768.96)
2.3.11	Эздийн өмчийн дүн	215,765,993.34	145,780,224.38
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨМЧ	215,765,993.34	162,826,044.23

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого	922,994,110.38	902,496,353.09
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг /алдагдал/	922,994,110.38	902,496,353.09
5	Хүүгийн орлого	-	356,807.45
6	Бусад орлого	109,337,438.17	410,728.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	904,683,183.90	973,249,657.50
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	127,648,364.65	(69,985,768.96)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	127,648,364.65	(69,985,768.96)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал)	127,648,364.65	(69,985,768.96)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
27	Нийт орлогын дүн	127,648,364.65	(69,985,768.96)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	865,534,177.20	936,335,771.88
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	865,534,177.20	936,335,771.88
1.1.6	Бусад орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	865,493,051.68	920,403,687.35
1.2.1	Ажиллагсад төлсөн	628,992,155.00	679,690,999.94
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,404,294.51	66,045,320.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	143,618,301.01	122,658,055.91
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	28,420,701.16	35,500,674.12
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	4,200,000.00
1.2.9	Бусад мөнгөн зардал	7,057,600.00	12,308,637.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	41,125.52	15,932,084.53
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	(15,139,892.55)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		356,807.45
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	15,496,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	15,496,700.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	41,125.52	792,191.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,745,518.59	1,786,644.11
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,786,644.11	2,578,836.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	55,379,883.21	3,914,334.64	28,823,410.84	88,117,628.69
Залруулсан үлдэгдэл	55,379,883.21	3,914,334.64	28,823,410.84	88,117,628.69
Тайлант үеийн ашиг (алдагдал)			127,648,364.65	127,648,364.65
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	55,379,883.21	3,914,334.64	156,471,775.49	215,765,993.34
Залруулсан үлдэгдэл	55,379,883.21	3,914,334.64	156,471,775.49	215,765,993.34

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх үйлстэн ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Тайлант үеийн ашиг (алдагдал)			(69,985,768.96)	(69,985,768.96)
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	55,379,883.21	3,914,334.64	86,486,006.53	145,780,224.38

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх үйлстэн ӨЭМТ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.2-т “Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайд дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна” гэж заасны дагуу эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэн бүрд тай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй хүргэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх үйлстэн ӨЭМТ нь “Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй, ёс зүйг дээдлэн, сэтгэл ханамжтай орчныг бүрдүүлэн ажиллах”, иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай хүргэх, эх хүүхдийн эрүүл мэнд, ахмад настны эрүүл мэндийг тасралтгүй үзүүлэх, эмнэлгийн ажилтны ёс зүйг дээдлэн сэтгэл ханамжтай үзүүлж ээлтэй орчныг бүрдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд нийт үзлэгийн тоо 60,913, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 33,056 гэрийн идэвхтэй эргэлт 14,642, амбулаторийн үзлэг 3,792, идэвхтэй хяналт 8,990, гэрийн дуудлагаар үзсэн 433 хүнд анхан шатны тусламж үйлчилгээг хүргэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Нөхөрлөлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм болон бусад холбогдох хууль, тогтоомж, тогтоод, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сард “Эрүүл мэндийн даатгалын 2025 оны төсвийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай”;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 04 дүгээр тогтоол “жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам, шинэчлэн тогтоох тухай”;
- Эрүүл мэндийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1-352 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдсэн байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийг Дотоод аудитын албанаас 2 жилд нэг удаа хяналт шалгалт хийдэг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдсэн боловч тайлан ирээгүй байна. ӨЭМТ-ийн дарга батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулдаг боловч дотоод хяналт хангалтгүй байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Оны эхний үлдэгдэл татвар, нийгмийн даатгалын санхүүжилтийн авлага 57,459.9 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг, алдагдлын дүн 57,459.9 мянган төгрөгийн зөрүүтэй тусгаагүй.	1	114,919.8			1	114,919.8	1	114,919.8				
Засаг даргын тамгын газрын гуравласан гэрээний дагуу ашиглалтын зардал 13,490.3 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй	1	13,490.3			1	13,490.3	1	13,490.3				
Дүн	3	128,410.1			1	128,410.1	1	128,410.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий 3 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний 50-70 хувь буюу 3,302.0 мянган төгрөгийг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тооцоогүй илүү олгосон байна.	1	3,302.0	1	3,302.0				
Бараа материалын 9,952.8 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ анхан шатны баримтын иж бүрдэл дутуу и баримтгүй гүйлгээ хийсэн нь өмнөх аудитаар илэрч байсан зөрчил давтагдаж байна.	1	9,952.8			1	9,952.8		
Ажилчдаас авах авлага 553.3 мянган төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо бодсон актгүй байна.	1	553.3					1	553.3
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо НБББББ-т тусгагдсан ашиглалтын жилийн хугацааг баримтлаагүйгээс 18 нэр төрлийн хөрөнгө 2,164.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцож зардал өсгөсөн.	1	2,164.3					1	2,164.3

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөнх үйлстэн ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн программ "acolus" нь шаардлага хангахгүй, хөгжүүлэлт, шинэчлэлтийг тогтмол хийлгэдэггүй байна. Тухайлбал оны эхний үлдэгдэл буруу татагдах, стауст хөрвүүлэхэд алдаа гарч байна.	1						1	
Дүн	5	15,972.4	1	3,302.0	1	9,952.8	3	2,717.6